



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/502

Номгон

Иргэдийн боловсрол, багш, удирдах ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, цахим болон танхимын сургалт зохион байгуулах, зардал олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.6, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6, аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний 6.1.5 дахь заалтын задаргааны 2 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн боловсрол, насан туршийн боловсролын багш, удирдах ажилтнуудыг чадавхыг дээшлүүлэх, цахим болон танхимын сургалт зохион байгуулах удирдамж, төсвийг хавсралтаар баталсугай.

2.Цахим сургалт арга хэмжээний зардал 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Цахим болон танхимын сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнахыг Насан туршийн боловсролын төв (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

012023 он 09 сарын 18 642311295